

ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА ЧУЛУУНЫ ХИШИГДАЛАЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2025 онд 579000 тоннд хүргэнэ.							
ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.							
1.	Арга хэмжээ 1.1 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөх.	Хөрөнгө оруулалт болон олборлолтын хэмжээ	190.8 сая ам.доллар, 568,725 тонн	10.0 сая ам.доллар	Монгол Улсын хэмжээнд Газрын тосны Баталгаат нөөц: Хайгуулын ажлын үр дүнгээр 2010, 2012, 2021 онуудад газрын тосны баталгаат нөөцийг 333.79 сая тонн гэж бүртгэсэн. Ашиглалтын баталгаат нөөц: 43.40 сая тонн -оор нөөцийн нэгдсэн санд бүртгэн авсан. Монгол Улсын хэмжээнд 43.40 сая тонн ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд 11.1 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 32.0 сая тонн байна. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл,	2025,01,01-2025,12,31	100

					хайгуулын ажлыг эрчимжүүлэх хүрээнд АМГТГ-ын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд гэрээлэгчдийн 2025 оны хөтөлбөр, төсвийг аж ахуйн нэгж тус бүрээр батлуулах ажлыг АМГТГ-тай хамтран зохион байгуулсан. Тайлант хугацаанд газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн нийт 5 ААН-ийн хүсэлт, хайгуул, судалгаатай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 105 албан бичиг хүлээн авч, шийдвэрлүүлсэн. 2021 оноос хойш хуримтлагдсан хайгуулын гэрээлэгч компаниудын талбай буцаан өгөхтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлж, ЭБМЗ-ийн Газрын тосны салбар зөвлөлийн 2025.11.13-ны өдрийн хуралдаанаар Төхөм Х урд, Гурвантэс XXXV, Онги V, Богд IV, Т-1, Тавантолгой XXXIII, Матад XX, Номгон IX зэрэг нийт 8 талбай хэсэгчлэн болон бүхэлд нь буцаах, хүлээн авах асуудлыг шийдвэрлүүлсэн. Өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын 10, уламжлалт бус газрын тосны хайгуулын 8 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул, судалгааны ажил үргэлжилж	
--	--	--	--	--	---	--

					байгаа бөгөөд 2025.12.01-ний өдрийн байдлаар гэрээлэгч компаниудын батлагдсан төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын дүн мэдээгээр нийт 60.9 сая ам.доллар улсын төсөвт төвлөрүүлсэн байна.		
	Арга хэмжээ 1.2 Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	Шинээр байгуулсан БХГ-ний тоо	3	2	Засгийн газрын №166, №167 дугаар тогтоолоор тус тус эрх олгосны дагуу газрын тосны хайгуулын Борзон-VII талбайд 2025.01.16-ны өдөр “Петро Матад Энержи Лимитед” ХХК-тай, уламжлалт бус газрын тосны хайгуулын Ачит-XXXVII талбайд 2025.01.06-ны өдөр “Тэмүүжин металс” ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) байгуулах ажлыг АМГТГ-тай хамтран зохион байгуулсан. 2025 онд нийт 2 БХГ шинээр байгуулж, зорилтод түвшинд хүрсэн. Хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд 2025 онд зөвхөн газрын тосны хайгуулын чиглэлээр 26 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд өмнөх оны мөн үеийн бодит гүйцэтгэлтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 6 сая орчим ам.доллараар нэмэгдэж, 21 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	2025.01.01-2025.06.15	100

2.	Арга хэмжээ 1.3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна.	ЭБМЗ-ийн газрын тосны салбар хуралдааны тоо	4 талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.	Нөөц нэмэгдсэн байна.	Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Галба XI талбайд Зон хэн юу тиан ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-г баталсан. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг 2009 оны 07 дугаар сарын 23-ны өдөр авсан. Зон хэн юу тиан ХХК нь 2009-2019 онд Галба XI талбайн Өлгий хотгорт нийт 1316 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 358 км ² талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуул, үнэлгээний 14 цооног өрөмдөж, нийт 20628 тууш метр өрөмдлөг хийсэн. 8 цооногоос авсан чөмөг чулуун дээжинд лабораторийн шинжилгээ хийж, 6 цооногт туршилт, үнэлгээ хийсэн. БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан	2025,01,01-2025,12,31	100
----	---	---	---	-----------------------	---	-----------------------	-----

				Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, Магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, Боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн болно. Монгол Улсад газрын тосны ашиглалтын баталгаат нөөц 43,4 сая тонн байсан бол Галба-ХI талбайн Өлгийн ордын газрын тосны нөөцийг хүлээн авснаар 44,5 сая тонн болж нэмэгдсэн болно.		
--	--	--	--	--	--	--

	Арга хэмжээ 1.4. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх.	Газрын тосны олборлолт, мян.тн.	568,725 тонн	200,000 тонн	Монгол Улсын хэмжээнд 44.50 сая тонн ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2024 оны хооронд 11.5 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 33.0 сая тонн байна. Улсын хэмжээнд газрын тосны олборлолт ашиглалтын үйл ажиллагааг Петрочайна дачин тамсан ХХК, Донүен газрын тос /Монгол/ ХХК болон Петроматад ХХК гүйцэтгэж байна. 2025 онд нийт 4 248 850 баррель буюу 579 000 тонн газрын тос олборлож экспортлохоос 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 3 420 159 баррель буюу 464 183 тонн газрын тос олборлож, 3 227 878 баррель буюу 438 736 тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Олборлолтын гүйцэтгэл 80,5 %, экспортын гүйцэтгэл 75,97%- тай байна. Газрын тосны орлогоос 249,6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 203,4 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна гүйцэтгэл 81,48 % -тай байна. 2025 онд олборлолтын	2025,01,01-2025,12,31	75
--	--	--	---------------------	---------------------	---	------------------------------	-----------

					цооног нэмж өрөмдөөгүйгээс шалтгаалан олборлолт нэмэгдээгүй байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр олборлолт экспортын хэмжээ 91 %-д хүрэхээр байна.		
	Арга хэмжээ 1.5. Газрын тос хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх ажлыг бодлогын удирдамжаар хангах;	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлү үлсэн байна.	3	1	Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/76 дугаар захирамжаар газар ашиглах зөвшөөрлийг олгосон, мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас газрын тос ашиглах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй болсон зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөө, нөхцөл байдлыг үндэслэн газрын тосны Матад-ХХ талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй “Петро Матад” ХХК-ийн газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэхээр шинэчлэн тогтоож, 2049 оны 05 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаагаар олгох тухай АҮЭБСайдын 2025.06.04-ний өдрийн А/145 тоот тушаал гаргуулсан. Мөн 974 тоот газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг “Петро Матад” ХХК-д олгоод байна.	2025,01,01-2025,12,31	100

				Тусгай зөвшөөрлийн www.license.mn цахим системээр дамжуулан хүсэлт ирүүлсэн “Монголиа Фойсон Энержи” ХХК-д газрын тосны хайгуулын Хэрлэн тохой-XXVIII талбайд газрын тос хайх, “Петроматад энержи” ХХК-д Борзон-VII талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг тус тус шинээр олгох ажлыг зохион байгуулсан. Мөн газрын тосны хайгуулын Арбулаг ХХIX талбайд үйл ажиллагаа явуулж буй “Макс-Ойл” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.08.22-ны өдрийн А/180 дугаар тушаалаар, Төхөм Х урд талбайд үйл ажиллагаа явуулж буй “Монголын алт (МАК)” ХХК-ийн газрын тос хайх зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.09.22-ны өдрийн А/203 дугаар тушаалаар тус тус сунгах ажлыг зохион байгуулсан.		
Зорилт-2: Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.						
	Арга хэмжээ 2.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулах	Газрын тосны бүтээгдэхүүн, сая тн.	2024 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ 2.8	2.5 сая тн	2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2,6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх Аи-92 автобензин 740 мян.тонн, Аи-95/98 автобензин 15 мян.тонн, дизелийн түлш 1,620	2025.01.01-2025.12.31 100

				мян.тонн, нийт 2,4 сая тонн шатахуун байна. Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбооноос 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 25/02 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Манай Улсын газрын тосны бүтээгдэхүүний гол нийлүүлэгчдийн нэг болох ОХУ-ын Газпром Нефть компани нь АНУ-ын Сангийн яамнаас 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гаргасан хоригт орсон тул Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд АНУ-ын Сангийн яамны Гадаад хөрөнгийн хяналтын алба /U.S.Department of the Treasury, Office of Foreign Assets Control/-нд нөхцөл байдлыг уламжлан, шаардлагатай тайлбарыг хүргүүлж, холбогдох зөвлөмж, зөвшөөрлийг авах асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахыг хүссэн албан бичгийг Монгол банкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02/234 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
--	--	--	--	---	--	--

				- Ангарск үйлдвэрийн засвартай холбоотойгоор 7 дугаар сарын худалдан авалтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, 8 болон 9 дүгээр саруудад Аи-92 автобензинийг 50 мян.тн-оос багагүй хэмжээгээр нэмэгдүүлж нөөц бүрдүүлэх хэрэгтэй байгаа тул арга хэмжээ авч ажиллах тухай ОХУ-ын Роснефть компанийн олон улсын хамтын ажиллагааны захирал А.В.Богатенков-д 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07/1893 дугаар албан тоотоор хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн №146 дугаар тогтоолоор Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” аж ахуйн тооцоотой үйлдвэрийг татан буулгах, мөн тус үйлдвэрийн газрын үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт “Эрчис ойл” ТӨХХК-д шилжүүлэх тухай засгийн газрын шийдвэр гарсан тул тус ажлыг яаралтай зохион байгуулж хамтран ажиллахыг хүссэн тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл-д 2025 оны 04 дүгээр сарын 09-ний		
--	--	--	--	--	--	--

				өдрийн 01/1056 дугаар албан бичгээр хүргүүлж 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А1/2200 дугаар албан бичгээр тогтоолын хэрэгжилт хангагдсан талаар албан тоот ирсэн болно. - ОХУ-ын экспортын хоригтой холбоотойгоор баруун бүсийн Ташанта-Цагааннуур, Хандгайт-Боршоо боомтуудаар шатахуун нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд А.А.Козлов-т 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/2219 дугаар албан тоотоор, “Роснефть Монголиа” ХХК-д 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 03/3032 дугаар албан тоотоор хүргүүлсэн. - Монгол Улсад Агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн талаарх саналийг нийт 16 яамдуудаас албан бичгээр нэгтгэн авч, УИХ-ын холбогдох Байнгын хороодоос ирүүлсэн саналын дагуу тус хэлэлцээрт оруулах		
--	--	--	--	---	--	--

				нэмэлт, өөрчлөлтийн талаар ОХУ-ын Эрчим хүчний яам болон “Роснефть” компанитай хамтран ажиллаж, 2025 оны 09 дүгээр сард ОХУ-ын Владивосток хотноо зохион байгуулагдсан “Дорнын эдийн засгийн чуулга уулзалт”, 10 дугаар сард Москва хотноо зохион байгуулагдсан Эрчим хүчний форум, 11 сард зохион байгуулсан ШХАБ-ын уулзалтуудын үеэр тус тус хэлэлцээрийн талаар ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилев болон бусад албаны хүмүүстэй уулзаж манай талын саналыг тавьж, хэлэлцсэн болно. Уг ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ОХУ-ын Эрчим хүчний нэгдүгээр орлогч сайд П.Ю.Сорокиной цахим уулзалт зохион байгуулж, тус хэлэлцээрийн талаар хэлэлцэж, санал солилцсон. Хэлэлцээрийн төслийг ОХУ-ын талтай эцэслэн тохирох ажиллагааг шуурхай зохион байгуулахад шаардлагатай бүх талын дэмжлэгийг үзүүлж хамтран ажиллах талаар уламжилж өгөхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/3421 дугаар албан тоотоор хүргүүлсэн.		
--	--	--	--	---	--	--

					- ОХУ-ын Роснефть компаниас 2025 оны 12 дугаар сард Аи-92 автобензин 58,660 тонн, Аи-95 автобензин 1,560 тонн, дизелийн түлш 89,240 тонн, Газпромнефть компаниас 4,000 тонн Аи-92 автобензин, 10,000 тонн дизель түлш, Нефтьхимисервис компаниас 30,000 тонн дизель түлш буюу нийт 193,460 тонн шатахуун худалдан авахаар захиалаад байна		
	Арга хэмжээ 2.2. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Евро-5 стандарты н шатахууны хэрэглээ, хувиар.	201.342 тн	228.188 тн	-2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2,6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 2,4 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 333 мян.тонн буюу нийт шатахууны 14 хувийг эзэлж байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад /Евро-5/ ангилалын шатахууны нийт импорт 11 мян.тонноор өссөн үзүүлэлттэй байна. -Монгол Улсын байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭГ/121 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Засгийн газрын авто бааз” ТӨҮГ, Нийтийн тээврийн	2025.01.01- 2025.12.31	100

				бодлогын газарт өөрийн авто бааз болон хөдөө орон нутгийн төрийн үйлчилгээнд хэрэглэгдэж буй авто тээврийн түлш, шатахууны худалдан авалтын сонгон шалгаруулалтыг зарлахдаа зөвхөн экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлш сонгох шаардлага тавьж, гэрээ байгуулах, хэрэглээ, худалдан авалтыг тогтмол нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, бидний ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах талаар хүсэлтийг 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02/231 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Пао «НК «Роснефть»-ийн Худалдаа, логистикийн дэд ерөнхийлөгч А.В.БОГАТЕНКОВ-аас 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн ИСХ-АБ-00607-25 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд K5/Евро-5/стандартын шатахууны хэрэглээний төлөвлөгөөг мөн үйлдвэрлэгч, нийлүүлэгч тал K5/Евро-5/ стандартад шилжвэл бид мөн шилжихэд	
--	--	--	--	--	--

					бэлэн байна гэх утгатай албан бичгийн хариуг 02 дүгээр сарын 06-ны өдрийн 01/363 дугаар албан бичгээр ГХЯ-аар уламжлуулан хүргүүлсэн. - ПАО Газпром тамгын газрын даргад тус компаниас худалдан авч буй к5/Евро-5/ стандартын дизель түлш, к5/Евро-5/ Аи-92 автобензинийн өмнөх тохиролцсон хэмжээнээс нэмэгдүүлэх тухай албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02/515 дугаар тоотоор хүргүүлсэн. 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/363 дугаар албан тоотоор Нийлүүлж буй шатахууны 30 хувиас багагүй хувийг Евро-5 стандартаар нийлүүлж хамтран ажиллах тухай Роснефть компанийн Худалдаа, логистикийн дэд ерөнхийлөгч А.В.Богатенков-д хүргүүлсэн.		
	Арга хэмжээ 2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэл, улсын төсвийн хөрөнгөөр улсын нөөцийн шатахууны агуулахыг барьж байгуулна	Улсын нөөцийн шатахууны агуулахыг барьж байгуулна. Хувиар	2024 оны байдлаар Ажлын хэсэг байгуулж тооцоо, судалгаа зураг төслийн санхүүжилтийг ЭЗХЯ-ны төсөвт суулгасан.	Барилгын ажил 10 хувь	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж тусгагдсан. Тус	2025.01.01-2025.12.31	100

				зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд шатахууны улсын нөөц бүрдүүлэх, хадгалахад шаардлагатай агуулахын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах төслийн бэлтгэл ажлыг хангах, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулах шаардлага тулгарч Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэж, яамдын бүх сайд нараас санал авч нэгтгэн товъёолж Засгийн газраар хэлэлцүүлэн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан байна. 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/2813 дугаар албан бичгээр МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтод "Газрын тосны бүтээгдэхүүний импорт, цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Шатахууны нөөцийн агуулахын багтаамж, хүчин чадлыг богино хугацаанд 30 хоногоор нэмэгдүүлэх шаардлагатай тухай танилцуулгыг бэлтгэн, яамдуудаас санал авч нэгтгэн хүргүүлсэн. Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэн		
--	--	--	--	--	--	--

				боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба гүйцэтгэгчээр “Шунхлай” ХХК шалгарч, Гашуунсухайтын боомтын шилжүүлэн ачих байгууламж, агуулахын хадгалах хүчин чадал 10 мянган метр куб, Шивээхүрэнгийн боомтын шилжүүлэн ачих агуулахын хадгалах хүчин чадал 5 мянган метр куб байх бөгөөд хоногт нийт 1,200 тонн газрын тосны бүтээгдэхүүн хүлээн авах буюу жилд 200,000 тонн газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авч, шилжүүлэн ачих хүчин чадалтай байхаар төлөвлөгдөн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.		
Арга хэмжээ 2.4. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.	Компанийн нөөцийн хэмжээ, мян.тн.	132,7	179,8	- 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд Аи-92 автобензин 13 хоног, Аи-95 автобензин 15 хоног, дизель түлш 14 хоног, ТС-1 онгоцны түлш 16 хоногийн ердийн хэрэглээний үлдэгдэлтэй байна. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар дундажаар шатдаг хийн ердийн хэрэглээний 36	2025.01.01-2025.12.31	100

				хоногийн үлдэгдэл, нөөцтэй байна. Үүнээс автомашиныг хийгээр цэнэглэх станцын үлдэгдэл 14 хоног, Хий цэнэглэх станц буюу агуулахын үлдэгдэл 22 хоногийн нөөцтэй байна. - Монгол Улс, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга О.НАРАНДЭЛГЭР-ээс 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02/354 дугаартай албан бичигтэй холбогдуулан Монгол Улс болон Оросын Холбооны Улс хоорондын хилийн боомтуудыг уялдаатай хөгжүүлэх, шинэчлэх боломжийг тодорхойлох, хоёр улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, тээвэр, логистикийн хамтын ажиллагааны асуудлыг зохицуулах үүрэг бүхий Монгол, Оросын ажлын хэсэгт Завхан аймгийн Тэс суманд байрладаг Арцсуурь боомт болон ОХУ-ын Цагаан толгой боомтуудын ажиллагааг сэргээж газрын тосны бүтээгдэхүүний авто тээвэр хийхтэй холбоотой асуудал хэлэлцүүлэх саналтай байгаа талаарх албан бичгийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 07/874 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

	Арга хэмжээ 3.1. “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах” ажлын хүрээнд эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, норм, стандартын төсөлд санал боловсруулах, газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Гүйцэтгэсэн ажлын тоо	1	Жилд 1 удаа	АҮЭБ-ийн Сайдын 2025 оны А/18 дугаар тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг хуулийн төсөл, холбогдох хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулж байна.	2025.01.01-2025.12.31	100
	Арга хэмжээ 3.2. Газрын тосны салбарын судалгаа, мэдээ, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	Мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг салбарын мэдээллээр хангах .	-	Салбарын мэдээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх	- Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн үнэ, импорт, үлдэгдэл, гадаад зах зээлийн үнийн мэдээг 7 хоног бүр шинэчлэн гаргаж яамны удирдлагуудыг тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.	2025.01.01-2025.12.31	100
	Арга хэмжээ 3.3. Газрын тосны гадаад дотоод зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, мэдээллийг нэгтгэх,	Салбарын зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг салбарын мэдээллээр хангах	-	Салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим санг бий болгох, хөгжүүлэх	-Газрын тосны олон улсын бирж дээрх “Брент” болон “WTI” төрлийн газрын тосны үнийг 7 хоног бүр шинэчлэн гаргаж, дэлхийн газрын тосны зах зээлийн мэдээг тогтмол нэгтгэн яамны шуурхай хуралдаанд удирдлагад танилцуулан ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд Аи-92 автобензиний жижиглэнгийн үнийг 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод литр тутамд 2590 төгрөг болгож 200 төгрөгөөр нэмэгдүүлсэн	2025.01.01-2025.12,31	100

					байна. Эдгээр ААН-үүдийн гаргасан үйлдэл нь Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.2-т заасан “Давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох” гэсэн заалтыг болон бусад хууль, тогтоомжийг зөрчсөн эсэхийг шалгаж өгч, хамтран ажиллахыг хүссэн албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1599 дугаар тоотойр Монополийн эсрэг газар хүргүүлсэн.		
	Арга хэмжээ 3.4. Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл нөөцийн мэдээг тогтмол авах ажлыг цахимжуулах асуудлыг зохион байгуулах		0	1	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл, нөөцийн мэдээг цахим сайт болох (mpetro.smartsolution.mn)-ээр 7 хоногт 2 удаа ААН-үүдээс авч мэдээллийг тухай бүр шинэчлэн гаргаж байна. Аи-92 автобензины тасалдал үүссэнтэй холбоотойгоор 2025 оны 10 дугаар сарын 01-нээс 12 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл Улаанбаатар хотын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл, нөөцийн мэдээг тогтмол авч яамны удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.	2025.01.01- 2025.12.31	100

Зорилго 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа

Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

	Газар, хэлтсийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулах, газрын 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх.	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	ГТБХЗГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж ТЗУГ-т хүргүүлэн батлуулсан.	2025.01.01-2025,12.31	100
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 1, 2 болон 3, 4 дүгээр улирлын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.	2025.01.01-2025.12.31	100
	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.01-2025.12,31	100
	2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-			Тухай бүр нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хугацаанд нь цахимаар хүргүүлсэн.	2025.01.01-2025.12.31	100

		хэрэгжүүлэ эгүй 1- хэрэгжүүлс эн	0	1			
	Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0- хэрэгжүүлэ эгүй 1- хэрэгжүүлс эн	0	1	Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.01- 2025.12.31	100
	Алсын хараа 2050-ын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0- хэрэгжүүлэ эгүй 1- хэрэгжүүлс эн	0	1	Алсын хараа 2050-ын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.01- 2025.12.31	100
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0- хэрэгжүүлэ эгүй 1- хэрэгжүүлс эн	0	1	- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 1, 2 болон 3 дугаар улирлын Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.	2025.01.01- 2025.12.31	100

	Шинэ сэргэлийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	Шинэ сэргэлийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.01-2025.12.31	100
	АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	ГТБХЗГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж ТЗУГ-т хүргүүлэн батлуулсан.	2025.01.01-2025.12.31	100
	Сарын ажлын тайлан нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх	Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлэ эгүй 1-хэрэгжүүлс эн	0	1	Тухай бүр нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хугацаанд нь цахимаар хүргүүлсэн.	2025.01.01-2025.12.31	100
	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих	70%	80%	Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр ирүүлсэн нийт 787 хүсэлт хүлээн авч, 426 албан бичгээр хариу хүргүүлж хугацаанд нь шийдвэрлүүлсэн. Хугацаа	2025.01.01-2025.12.31	100

		шийдвэрлэлтийн % 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн			хэтэрсэн шийдвэрлэлт байхгүй.		
	Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах.	Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх	Бичиг хэргийн шийдвэрлэлт 91 %	92%	Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2025.01.01-2025.12.31	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн цахим сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдах	-	Сургалтанд хамрагдсан байна	ХХЕГ болон ОБЕГ-аас цэргийн албан хаагчтай холбоотой эрх зүйн шинэчлэлтэй холбоотой мөн гамшгийн үед авах арга хэмжээний талаар зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	2025.01.01-2025.12.31	100

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн шууд захирагч

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг

.....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

.....

Тайлагнасан:

Нэгжийн дарга

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

.....